

**Монголын “Герман Судлал” Төвийг Үүсгэн
Байгуулагчдын 2002 оны 4 дүгээр сарын
17-ны өдрийн Хурлаас батлав.**

**МОНГОЛЫН “ГЕРМАН СУДЛАЛ”
ТӨВИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Төв нь Монгол Улсад Герман судлалыг бүх талаар хөхүүлэн дэмжиж хөгжүүлэхийн тулд олон нийтийн төрөл бүрийн байгууллага болон шинжлэх ухаан, соёл урлаг, нийгэм, төрийн зүтгэлтэн, эрдэмтэн судлаачид, оюутан багш нар, ажил хэрэгч буюу хувь хүмүүсийн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн “нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага” мөн.

1.2 Төв нь Монгол Улсын Төрийн бус байгууллага (ТББ)-ын нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

1.3 Төв нь ТББ-ын хувьд Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд тус улсын үндсэн хууль болон бусад холбогдох үндэсний ба олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулсан дүрмийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулна.

1.4 Төв нь өөрийн тамга, албан бичгийн хуудас, нэрийн хаягтай байна.

**Хоёр. Төвийн зорилго, үйл ажиллагааны
үндсэн чиглэл**

2.1 Төв нь Монгол Улсад Герман судлалыг бүх талаар хөхүүлэн дэмжиж хөгжүүлэх, Германы нийгэм эдийн засгийн хөгжил, дэвшил, шинжлэх ухаан, соёл, боловсролын салбар дахь тэргүүний ололт амжилтыг өргөнөөр сурталчлан таниулахад тус дөхөм үзүүлэх явдлыг гол зорилгоо болгоно.

2.2 Энэ зорилгын тулд Төв нь зохих байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр судалгаа, мэдээллийн сэтгүүлийг

хэвлэн нийтлүүлж, нийтийн хүртээл болгож байна. Мөн тодорхой сэдэв, төслөөр дагнасан ба хамтарсан судалгаа хийх, судалгааны бүтээл туурвих, орчуулах, хэвлэн нийтлэх явдлыг төвлөрүүлж зохицуулна.

2.3 Өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу дотоод, гадаадын байгууллага, хувь хүмүүстэй ажил хэргийн холбоо тогтоож хамтран ажиллах, олон улсын төрөл бүрийн хурал, симпозиум, уулзалт, семинар зэрэг арга хэмжээнд идэвхтэй оролцож, мөн тийм арга хэмжээг Төв нь зохион явуулж байна.

2.4 Төв нь гишүүдийнхээ ажил мэргэжлийг дээшлүүлэх, хэлний дадлага хийлгэх, туршлага судлуулах, судалгааны томилолтоор явуулж ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

2.5 Төвийн үйл ажиллагаа нь Монгол, Германы ард түмэн, олон нийтийн хооронд нөхөрсөг хэлхээ холбоо, тал бүрийн хамтын ажиллагааг бүхий л аргаар дэмжин хөгжүүлэх улмаар улс орноо Герман ертөнцөд сурталчлан танилцуулах үйлсэд бүрэн чиглэнэ.

Гурав. Төвийн бүтэц, зохион байгуулалт

3.1 Төвийн эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.

3.2 Бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Хурлаар Төвийн дүрмийн нэмэлт өөрчлөлт, Удирдах Зөвлөлийг сонгох, шинэчлэх, огцруулах мөн Төвийг өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг асуудал ба ажлын тайлан, үйл ажиллагааны цаашдын чиглэлийн талаар хэлэлцэж зохих шийдвэр гаргахын хамт Төвийн жилийн төсвийг батална.

3.3 Бүх гишүүдийн ердийн олонхийн ирцээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.4 Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг гишүүдийн ердийн олонхийн саналаар батална.

3.5 Төвийн өдөр тутмын ажил хэргийг бүх гишүүдийн хурлаас хоёр жил тутам сонгогдох 11 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах Зөвлөл, түүнээс сонгосон Төвийн тэргүүн, дэд тэргүүн

нар, гүйцэтгэх захирал шууд хариуцан явуулна.

3.6 Удирдах Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй хуралдаж, цаг үеийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.

3.7 Удирдах Зөвлөлийн гишүүдийн ердийн олонхийн ирцээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.8 Удирдах Зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар батална.

3.9 Төв нь өөрийн мэдэлд судалгаа-мэдээллийн бие даасан хэвлэлтэй байна. Жилд гаргах дугаарын тоог Удирдах Зөвлөлөөс тогтооно.

Дөрөв. Гишүүн, гишүүнчлэл

4.1 Төв нь ардчилсан төвлөн удирдах зарчимд тулгуурласан нээлттэй байгууллага байх бөгөөд түүний дүрмийн үүрэг зорилго, үйл ажиллагааг дэмждэг хэн боловч гишүүнээр элсэх ба тодорхой шалтгаанаар гишүүнээс татгалзах, түтгэлзэх бүрэн эрхтэй.

4.2 Төвийг санаачлан зохион байгуулагчдыг гишүүнээр шууд элссэнд тооцох бөгөөд анхдагч гишүүд болно. Гишүүн болох сонирхолтой хүмүүс санал хүсэлтээ Удирдах Зөвлөлд илэрхийлэн элсэж болно.

4.3 Төвийн үүрэг зорилгыг хүндэтгэн үзсэн гадаадын иргэд гишүүн байж болно.

4.4 Гишүүн бүр Төвийн үйл ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцох ба бүх гишүүд Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг ёсчилон биелүүлнэ.

4.5 Гишүүд санал хүсэлт, өргөдөл гомдлоо чөлөөтэй илэрхийлэх эрх эдэлнэ.

4.6 Төвийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж, их хувь нэмэр оруулсан монголын ба гадаадын иргэд, гишүүддээ “хүндэт өргөмжлөл” хүртээж алдаршуулах ажил зохионо.

Тав. Төвийн санхүүжилт

5.1 Төвийн санхүүгийн эх үүсвэр нь гишүүдээс болон Монголын ба гадаадын талархан дэмжигч, ивээн тэтгэгч байгууллага, хамт олон, хувь хүмүүсээс оруулах хандив, судалгаа, сурталчилгааны бүтээл, хэвлэл нийтлэл, урлаг соёлын арга хэмжээ болон бусад үйлчилгээнээс орох орлого зэргээс бүрдэнэ.

5.2 Төвийн гишүүдээс ба бусад байгууллага, хувь хүмүүсээс өгөх хандивийн тоо хэмжээг тогтоохгүй бөгөөд өөрсдийн боломж саналаараа оруулах ба тэр нь төгрөг, валютын ямар ч хэлбэрээр байж болно.

5.3 Төвийн мөнгөн санхүүг судалгаа, сурталчилгаа, шагнал урамшил, гадаад, дотоодын төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах ба оролцох, гишүүдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, зочид хүлээж авах үйлчилгээ зэрэгт зарцуулна.

5.4 Мөнгөн санхүүгийн зарцуулалтанд Төвийн Удирдах Зөвлөл хяналт тавьж ажиллана.

Зургаа. Төвийг татан буулгах журам

6.1 Төвийн Дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан болон дүрэмд заасан бусад үндэслэлээр татан буулгаж болно. Ийнхүү татан буулгах тухай шийдвэрийг Төвийн эрх барих дээд байгууллага болох бүх гишүүдийн хурал гаргаана.

6.2 Төвийн Дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, хууль тогтоомж ноцтой, эсвэл удаа дараа зөрчсөн тохиолдолд шүүх албадан татан буулгаж болно.

6.3 Төвийг татан буулгасан нөхцөлд зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрвээ тийм төрийн бус байгууллага байхгүй бол зорилгодоо нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

Улаанбаатар хот
2002 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр